

Бүлэг:4 “ Хүний эрх ба хууль”
Сэдэв: Хүүхдүүд эрхээ яаж хамгаалах вэ?

Хамрах хүрээ: 7 анги

УЛААНБААТАР

2021

Энэхүү сэдвийг судалснаар хүүхдийн эрх хэрхэн хэрэгждэг талаар мэдэж, өөрийн болон бусдын эрхийг хэрэгжүүлж, зөрчигдсөн тохиолдолд хамгаалах чадвартай болох юм.

Өмнөх хичээлээрээ дараах ойлголтуудыг

- Эрх гэж юу вэ?
- Хүүхдүүд ямар эрхтэй вэ?
- Үүрэг гэж юу вэ?
- Эрхээ эдэлж байгаа бол үүргээ биелүүлэх шаардлагатай талаар үзэж судалсан.

Эрхийн хэрэгжилт

Хүний эрх, эрхийн хэрэгжилт улс үндэстний уламжлал, зан заншил, эдийн засаг, иргэдийн мэдлэг боловсрол зэргээс шалтгаалан харилцан адилгүй байна.

Мөн хүмүүс, хүүхдүүд эрхийнхээ талаар мэдэхгүй байх нь эрхээ хэрэгжүүлж, хамгаалж чадахгүй байдалд хүргэдэг. Иймээс зөрчигдсөн үед хэрхэн эрхээ хамгаалах талаар мэдлэгтэй байх нь маш чухал юм.

Хүний эрх цаасан дээр бичигдэх төдий бус бид хаана байна, тэнд хэрэгжиж байх ёстой. Жишээлбэл: Гэр бүлийн гишүүдээ хүндлэх, дүүгээ унтаж байхад нь хөгжим чанга тавихгүй байх, бусдын зүйлийг зөвшөөрөлгүй авахгүй байх зэрэг.

Ангидаа болон сургуулийн орчинд хүүхдийн эрхийн

№	Тохиолдол	тийм	үгүй
1	Анги цэвэрлэх, хог асгах ажлыг ихэвчлэн охид хийдэг.		
2	Сурагч нар бие биедээ хоч өгч, шоолох тохиолдол байдаг.		
3	Бид заримдаа нэгнийхээ яриаг анхаарч сонсдоггүй.		
4	Найзынхаа эд зүйлс зөвшөөрөлгүй хүрдэг.		
5	Сурагчид нэг нэгнээ яс үндсээр нь дооглон тохуурхсан үг хэллэг хэрэглэх үе байдаг		
6	Зарим багш нийтийн дунд сурагчид болон тэдний эцэг эхийн талаар шүүмжлэх тохиолдол гардаг		
7	Сурагчдын дунд өгсөн багийн ажилд зарим сурагч идэвх санаачлагатай оролцдоггүй		

Хүүхдүүд та нар эрхээ хэрхэн хамгаалах вэ?

Тухайлбал: 1.Ээж надаас асуулгүй сургуулийг маань солих шийдвэр гаргасан.

- Зөрчигдсөн эрх- Санал бодлоо илэрхийлэх
- Эрхээ хэрхэн хамгаалах- Өөрийн саналыг сонсох хэрэгтэй талаар ээждээ хэлж, ярилцах

2. 11ангийн сурагч Б сургуулийн хашаанд хог хаяж, тамхи татсан.

- Зөрчигдсөн эрх- Бусдын эрүүл орчинд сурч боловсрох, амьдрах эрхийг зөрчсөн
- Эрхээ хэрхэн хамгаалах- Энэ талаар холбогдох хүнд(сургуулийн нийгмийн ажилтанд) мэдээлэл өгсөн.

Хүүхдийн эрхийг хамгаалахад хэн хамгийн гол үүрэгтэй вэ?

Хүүхдийн эрхийг хамгаалахын тулд олон гэрээ, конвенц, хууль тогтоомж гарсан байдаг талаар бид үзсэн шүү дээ. Гэвч бодит амьдрал дээр бидний эрх хэрэгжихгүй зөрчигдөх тохиолдол байдаг. Иймээс эрхээ хамгаалж сурах аюулгүй байдлаа бүрдүүлэхэд **хүүхэд бүрийн оролцоо** чухал юм.

Хүүхдүүд та нар эрхээ хамгаалахын тулд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах чадвартай байх хэрэгтэй.

Тухайлбал:

- сургуулийн номын санд сурагчийн зайлшгүй уншиж судлах номын хүрэлцээ муу байвал сурагч ном авах талаар хүсэлт гаргаж болно.
- Ангийн найздаа нэр хоч өгч, зохисгүй харилцсан байна. Сурагч энэ талаар гомдол гаргаж болно.
- Бат, Туяагаас зээл мөнгөө цаг хугацаанд нь өгөөгүй байна. Бат мөнгө буцааж авах талаар нэмэмжлэл гаргаж болно.

Зөрчигдсөн эрхийг хамгаалах үе шатууд

- Анхны эрхийг сэргээх
- Анхны эрхийг сэргээх боломжгүй бол нөхөн төлбөр төлөх
- Нөхөн сэргээж эмчлэх(Бие махбодь, сэтгэл санаа, санхүү)
- Уучлалт гуйж дахин давтагдахгүй байх баталгаа гаргах
- Хуульд заасан хариуцлага тооцох

Сурагчид та нар хуулийн талаар юу юу мэддэг вэ? Эрэгцүүлэн бодоорой

Хууль бол бидний эрхийг хамгаалах хэрэгсэл юм.

Хуулийг даагж мөрдөх нь өөрийн болон бусдын эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах гол арга зам юм. Үүнтэй холбоотой үлгэрийг бичлээ та бүгд уншаад дараах асуултуудыг эргэцүүлэн бодоорой.

- Хуульгүй нийгэм ямар байсан бэ?
- Иргэдийн бослогийн гол зорилго юу вэ?
- Тэд яагаад хуулийг дагаж мөрдөх хэрэгтэй болсон бэ?
- Хуулийн зорилгыг хэрхэн тайлбарлаж болох вэ?

Үлгэр

Эрт нэгэн цагт балмад хаан байжээ. Тэр хаан улс орноо ганцаараа удирдаж, хүмүүс түүний зарлигийг үг дуугүй дагадаг байлаа. Хаан иргэдээс эд хөрөнгө хурааж, өөрийн төлөө амь хайргүй зүтгэхийг шаардаж, шийдвэрийг эсэргүүцсэн хэнийг ч болов цаазалж, тарчлаан шийдтгэдэг эрх мэдэлтэй байжээ.

Эцэстээ хааны харигслал хэрээс хэтэрч ард иргэд нь “Бид өөрөөсөө бусад хэн нэгэнд захирагдана гэдэг нь “Ярьдаг өмч” буюу боолоос өөрцгүй. Иймээс бид төрөлх эрх, эрх чөлөө, бусад бие даасан байдлаа хамгаалах цор ганц арга нь өөрсдийн хүлээн зөвшөөрсөн шийдвэрт захирагдах арга юм байна хэмээн хааны эсрэг босох болжээ.

Бослогийн үр дүнд хүмүүс нийгмээ хэрхэн зохион байгуулах талаар хэлэлцэж тохирсон байна. Тэд амьдралынхаа чухал асуудлыг шийдэх эрхтэй удирдагчийг өөрсдийн зөвшөөрлийн дагуу томилж байхаар болов. Удирдагчийн үүрэг бол ард иргэдийнхээ амь бие, эрх чөлөө, өмч хөрөнгийг хамгаалах юм.

Харин тэрхүү удирдагчийг иргэд өөрсдөө сонгосон тул түүний гаргах шийдвэр буюу тогтоосон хуулийг сахих ёстой гэсэн зарчмыг хатуу баримтлах болжээ.



Хүмүүс авьяас билиг ур чадвар,
гадаад байдал дуртай зүйл зэрэг
хувийн шинжээрээ өөр өөр
байдаг. Гэхдээ хүн бүр хуулийн
өмнө адил тэгш эрхтэй юм.



Өөрөөр хэлбэл: Хүн бүр төрөлхөөсөө
адил тэгш эрхтэй тул хуулийн өмнө
эрх тэгш байна. Хүн бүр хуулиар
хамгаалуулах эрхтэй болохыг
Монгол Улсын Үндсэн хууль болон
бусад
хуульд баталгаажуулсан байдаг.

Дүгнэлт:

- Хүн бүхэн эрхээ мэдэж байж хамгаалуулах боломжтой.
- Эрхээ мэдэж байгаа хүн бусдын эрхийг зөрчихгүй
- Төрөөс иргэдийн эрхийг хамгаалахын тулд олон хууль тогтоомж батлан хэрэгжүүлдэг.
- Хууль нь хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулж, тэдний эрхийг хамгаалах хэрэгсэл болдог.
- Нэмэлт мэдээлэл: Хуулийг Улсын Их Хурал батлан гаргадаг.

Анхаарал хандуулсанд баярлалаа

- **Хууль гэж юу вэ?**
- **Нийгэм орон нутгийн болон хүмүүс хоорондын харилцааг зохицуулдаг хэм хэмжээг хууль гэдэг.**
- **Хууль** (Монгол хэлний тайлбар Толь бичигт) - хууль бол Засаг төрийн дээд эрхийг барих байгууллагаас улсын хэмжээгээр бүх нийтийг заавал дагаж мөрдүүлэхээр баталсан албан ёсны дүрэм, журам гэжээ.